

**ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ТАЛБАЙН УРД ХЭСГИЙН ТОХИЖИЛТЫН
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ УРАЛДААНЫ ДААЛГАВАР**

2019 оны 05 сарын 14-ны өдөр


Дугаар №

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; - Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/439 дугаар захирамж.
2	Төлөвлөлтийн байршил, хамрах хүрээ, гүйцэтгэх талбай	<ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 06 дугаар хороо, Жанжин Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт байрлах авто зогсоол, цэцэрлэгт хүрээлэн; - Сүхбаатарын талбай орчмын зам талбай, ногоон байгууламж, барилгажилт болон бусад зүйлсийг хамруулах; - Төлөвлөлтийн нийт талбай 2.5 га.
3	Зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"> - Жилийн дөрвөн улиралд олон төрийн зориулалтаар ашиглах нөхцөлийг хангасан, иргэд, олон нийт амрах, аялах тухтай орчинг бүрдүүлсэн тохижилт, ногоон байгууламж байгуулах.
4	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгт хүрээлэн; - Авто зогсоол; - Нийтийн бие засах газар.
5	Зураг төсөл гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"> - 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр.
6	Зураг төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын тамгын газар.
7	Зураг төсөл боловсруулах байгууллага	<ul style="list-style-type: none"> - Зураг төслийн мэргэжлийн байгууллага; - Хувь хүн, мэргэжлийн уран бүтээлчид, мэргэжлийн сургуулийн оюутан залуус зураг төслийн мэргэжлийн байгууллагатай хамтран оролцоно.
8	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Үндэсний түүх уламжлалыг харуулсан хөшөө дурсгалуудтай нийцсэн үндэсний хэв шинжийг тусгасан байх; - Улаанбаатар хотын ирээдүйн хөгжлийн чиг хандлага, олон нийтийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн байх; - Усан оргилуур болон усан толио бүхий агаар, орчны бохирдлыг бууруулах бичил уур амьсгалыг бүрдүүлэх; - Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн шийдлийг тусгасан байх; - Үндэсний ёс заншил, соёлыг сурталчлах, амралт зугаалгын төв болох; - Орчин үеийн дэвшилтэт технологийг тусгасан эрчим хүчний хэмнэлттэй байх; - Эдийн засаг болон нийгэмд үр өгөөжтэй байх; - Авто зам болон явган хүний хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлсэн байх; - Зураг төсөл зохиогч нь гараар эсвэл компьютер график ашиглан боловсруулах.

9	Зураг төслийн иж бүрдэл	<p>1. Тайлбар бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөлтийн талбай орчмын судалгаа, одоогийн байдлын дүн шинжилгээ дүгнэлтэд суурилсан, тухайн орчимд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, оновчтой төлөвлөлтийн шийдлийг тоон мэдээлэл болон эдийн засгийн бодит тооцоололд тулгуурлан боловсруулсан үзэл санааг тодорхой тайлбарласан байх; - Хэвлэлийн эх А4, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.doc, *.pdf, *.ppt/. <p>2. Зураглалын альбом:</p> <ul style="list-style-type: none"> - Сүхбаатарын талбай орчмын барилгажилт, зам талбай, дэд бүтцийн одоогийн байдлын суурь дэвсгэр зурагт үндэслэн, тухайн орчимд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, оновчтой төлөвлөлтийн шийдлийг тусган боловсруулах; - Хэвлэлийн эх А3 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.dwg, *.pdf, *.jpg, *.max, *.png/. <p>3. Танилцуулга /Үзэсгэлэнгийн самбар/:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд болон төр захиргааны удирдлагууд танилцах үзэсгэлэнд гаргах танилцуулгыг бусдаас ялгарах онцлог, давуу байдлаа харуулан зохиомжлон харуулах; - Хэвлэлийн эх 90x90 см форматаар, хэвлэмэл болон файл хэлбэрээр /*.pdf, *.jpg, *.png/.
10	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Бүтээлийн үзэл санаа, шинэлэг байдал; - Үндэсний онцлог, түүх, соёлын хэв шинжийг тусгасан байдал; - Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн шийдэл тусгасан байдал; - Ажлын гүйцэтгэл, иж бүрдлийн шаардлагыг хангасан байдал.

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН БАЙРШЛЫН СХЕМ



Эргэлтийн цэг

Д/А	Х	Ү
1	643183.8535	5308982.747
2	643371.3985	5309013.995
3	643387.4021	5308900.34
4	643372.518	5308887.007
5	643192.75	5308856.188
7	643185.6328	5308868.263
8	643193.3198	5308920.697

Тусгаа : WGS 1984 UTM Zone 48N

Масштаб 1 : 2,500

Таних тэмдэг Тохижилтын ажлын хил